



ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)


ДНБ-ий өсөлт: 2019 онд: +6.7%, 2020 онд: +6.3%
Инфляци: 2019 онд: +8.5%, 2020 онд: 7.5%
Урсгал тэнцэл: 2019 онд: ДНБ-ий -9.6%, 2020 онд: -13%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2019 оны тайланд тоймлосон байна.
ДНБ-ий өсөлт: 2019 онд: +6.3%
Инфляци: 2019 онд: +7.1%,
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2019 онд: -10.8%- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2019 он) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <http://bit.ly/2zsmvYo>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 3-р сарын байдлаар 107 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав.

Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үеэс 60.8 хувиар, зарлага 55.5 хувиар буурсан бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 107 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 81.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.



Ам.долларын ханш өмнөх сараас 0.8 төгрөгөөр буурав.

Гуравдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 237 төгрөг буюу 9.9 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 0.8 төгрөг буюу 0.03 хувиар буурч 2632.51 төгрөг болов. 2-р сарын байдлаар гадаад валютын нөөц 3.6 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас өөрчлөлтгүй, өмнөх оны мөн үеэс 22.2 хувь нэмэгдсэн байна.




Инфляцийн түвшин 6.7%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2019 оны 3-р сарын байдлаар өмнөх сараас 0.7 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 6.7 хувиар, оны эхнээс 1.8 хувь өсөв. Хүнсний бараа, орон сууц, ус, цахилгаан, хувцас, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ өссөн нь голлон нөлөөлжээ.



Гадаад худалдааны тэнцэл 485 сая.ам доллар болов.

2019 оны гуравдугаар сарын байдлаар нийт барааны эргэлт 3057 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 17 хувиар өссөн бол экспорт өмнөх сараас 19.5 импорт өмнөх оны мөн үеэс 13.7 хувиар өсч гадаад худалдааны тэнцэл 485 сая ам.долларын ашигтай гарлаа.



3-Р САРЫН ОНЦЛОХ: МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨР

Эх сурвалж: www.1212.mn

2018 оны дөрөвдүгээр улирлын байдлаар Засгийн газрын нийт гадаад өр 7 тэрбум ам.доллар, Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 28.7 тэрбум ам.доллар болсон байна. Энэ нь өмнөх улирлаас ЗГ-ын өр 2 хувь (158.8 сая ам.доллар), Улсын нийт гадаад өр 3% (831.8 сая ам.доллар)-иар тус тус өссөн байна. Харин төв банкны өр 2% буюу 34.3 сая ам.доллараар өссөн бол хадгаламжийн байгууллагуудын өр -3% буюу 78.4 сая ам.доллараар буурсан байна. Нийт гадаад өрийн 25%-ийг засгийн газрын өр, 7%-ийг Төв банкны өр, 8%-ийг хадгаламжийн байгууллагуудын өр, 28%-ийг бусад салбаруудын өр, 32%-ийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна.

САРЫН ОНЦЛОХ

2021 ОНООС МОНГОЛ УЛС БОНДЫН ӨР ТӨЛЖ ЭХЭЛНЭ.

- Засгийн газрын өрийн байдал, 2016 оны төгсгөлд, ДНБ-ний 78.8 хувийг эзэлж байсан бол, өнгөрсөн оны төгсгөлд 58.9 хувь болж буурсан. Төсөвт дарамт болдог барих, шилжүүлэх ажлыг энэ онд хийхгүй. Арилжааны хувьд, дотоод, гадаадын бонд авахгүй гэсэн бодлогыг баримталж байгаа. 2021 оноос томоохон бондуудын өр төлж эхэлнэ. Тухайлбал Мазаалай бондын 600 сая ам.доллар, 2022 онд Чингис бондын нэг тэрбум ам.доллар, 2023 онд Гэрэгэ бондын 800 сая ам.доллар, 2024 онд Хуралдай бондын 600 сая ам.доллар зэрэг нийт 2.9 тэрбум ам.долларын өрийг төлнө.

ЭКСПОРТ НЭМЭГДЭВ.

- Гаалийн ерөнхий газраас мэдээлснээр, нийт экспортын 75.5 хувийг эрдэс бүтээгдэхүүн эзэлсэн хэвээр байна. Тодруулбал, төмрийн хүдэр, чулуун нүүрс, зэс болон цайрын баяжмал, жонш, молибдений баяжмал, боловсруулаагүй нефть зэрэг эрдэс баялаг нь уул уурхайн бүтээгдэхүүний 98.4 хувийг эзэлж байна. Экспортын бүтцийг 2-р сарын эцсийн байдлаар авч үзвэл, нийт экспортын 75.5 хувь эрдэс бүтээгдэхүүнд; 17.9 хувь алтны экспортод, 2.3 хувь нэхмэлийн материал болон нэхмэл эдлэлийн экспортод тус тус ногдож байна. Мөн 4665.2 кг алт экспортлосон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 2969.2 кг-аар их байна. Алтны экспортын дундаж үнэ 2018 оны мөн үед 42561.6 ам.доллар байсан бол, энэ онд 41998.0 ам.доллар болж 563.6 ам.доллороор багассан байна. Алтны экспорт үнийн дүнгээр 195.9 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 123.7 сая ам.доллороор өсжээ. Түүнчлэн 4.2 мян.тонн адууны мах, 544.6 тн хонь, ямааны мах, 243.8 тн малын дайвар бүтээгдэхүүн экспортлосон байна.

Эх сурвалж:

- Статистикийн бюллетень, 3-р сар 2019 он, Үндэсний статистикийн хороо
- Статистикийн бюллетень, 3-р сар 2019 он, Монголбанк
- www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn.